

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2025/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn
Аудитор: Ж.Наранчимэг
Утас: 70350757 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, тогилуулгад гарсан өөрчлөлт	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.17 № 02
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОЮУНБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/845 дугаар захирамжийн дагуу Худалдан авах ажиллагааны газрыг байгуулж, 10 хүний бүрэлдэхүүнтэй худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хариуцлагатай, ил тод, нээлттэй зохион байгуулан тэгш, шударга өрсөлдөх таатай орчинг бүрдүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/89 дүгээр захирамжаар Орон нутгийн Өмчийн газраас 247,716.4 мянган төгрөгийн 207 ширхэг үндсэн хөрөнгө, 1,448.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэх авч, төсвийн хөрөнгөөр 62,665.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 22,393.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

D:\my doc\alban bichig-A4.doc

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 100 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Н.ПҮРЭВХАГВА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	6,320,400.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
34714	Томилолтын урьдчилгаа		
35	БАРАА МАТЕРИАЛ	-	6,320,400.00
351	Түүхий эд материал	-	2,733,400.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,733,400.00
354	Хангамжийн материал	-	3,587,000.00
35450	Барилгын засварын материал	-	3,587,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	231,554,029.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	231,554,029.34
392	Биет хөрөнгө	-	230,206,529.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	45,517,867.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(6,263,117.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	42,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(42,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	181,908,926.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(39,998,841.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	65,300,802.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(16,259,108.00)
393	Биет бус хөрөнгө	-	1,347,500.00
39301	Програм хангамж	-	1,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(302,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	237,874,429.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	237,874,429.34
51	Засгийн газрын хувь оролцоо	-	237,874,429.34
512	Хуримтлагдсан үр дүн	-	237,874,429.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	237,874,429.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	237,874,429.34

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	928,824,019.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	207,161,819.34
120	Нийтлэг татварын бус орлого	-	207,161,819.34
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	205,696,519.34

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан Үндсэн хөрөнгө		205,696,519.34
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан Бараа материал		1,465,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	721,662,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	34,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	34,720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	686,942,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	686,942,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	683,022,640.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	683,022,640.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	496,263,466.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	357,231,579.00
210101	Үндсэн цалин	-	161,236,736.00
210102	Нэмэгдэл	-	134,927,609.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	42,677,434.00
210104	Урамшуулал	-	18,389,809.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	42,627,382.64
210201	Гэтгэврийн даатгал	-	29,241,367.28
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,621,895.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,235,565.33
210204	Ажилгүйдлийн даатгал	-	768,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,759,854.84
2104	Хангамж, бараа материалын зардал	-	17,465,712.90
210401	Бичиг, хэрэг	-	12,317,300.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,610,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	790,012.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,748,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	413,000.00
210604	Урсгал засвар	-	413,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	25,220,100.00
210702	Дотоод албан томилолт	-	25,220,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,424,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	20,380,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	400,000.00
210804	Гэтгэврийн хэрэгслийн татвар	-	212,852.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,410,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	28,880,840.32
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	28,880,840.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	186,759,173.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	131,711,587.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,805,900.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,233,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	42,672,087.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	55,047,586.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	55,047,586.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	<u>245,801,379.02</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,926,949.68
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	7,926,949.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,926,949.68)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	<u>237,874,429.34</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	<u>721,662,200.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	721,662,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	34,720,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	34,720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	686,942,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	686,942,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	<u>658,996,900.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	658,996,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	472,237,726.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	357,231,579.00
210101	Үндсэн цалин	-	161,236,736.00
210102	Нэмэгдэл	-	134,927,609.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,677,431.00
210104	Урамшуулал	-	18,389,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	42,627,362.04
210201	Тэтгэврийн даатгал	-	29,241,367.28
210202	Тэтгэмжийн даатгал	-	3,621,895.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,235,565.33
210204	Ажилгүйдлийн даатгал	-	768,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	6,759,854.84
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,733,812.90
210401	Бичиг хэрэг	-	13,601,800.00

210402	Тээвэр, шатахуун	-	1,593,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	790,012.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	2,748,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	4,000,000.00
210604	Урсгал засвар	-	4,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	25,220,100.00
210702	Дотоод албан томилолт	-	25,220,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	24,424,852.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	20,380,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	
210803	Даатгалын үйлчилгээ	-	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	212,852.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,410,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	186,759,173.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	131,711,587.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,805,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	36,233,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	42,672,087.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	55,047,586.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	55,047,586.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	62,665,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	62,665,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	62,665,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	62,665,300.00
223001	Бусад хөрөнгө	-	62,665,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(62,665,300.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	237,874,429.34	-	237,874,429.34
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	237,874,429.34	-	237,874,429.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөрийн код	Зориулалт, арга хэмжээний код	Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
				Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
		1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
70101	80101	2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700,942,200.00	721,662,200.00
70101	80101	21	УРСГАЛ ЗАРДАЛ	700,942,200.00	666,614,613.54
70101	80101	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569,229,700.00	534,903,026.54
70101	80101	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,369,300.00	357,231,579.00
70101	80101	210101	Үндсэн цалин	171,585,500.00	161,236,736.00
70101	80101	210102	Нэмэгдэл	154,772,400.00	134,927,609.00
70101	80101	210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,800,000.00	42,677,434.00
70101	80101	210104	Урамшуулал	20,211,400.00	18,389,800.00
70101	80101	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,046,200.00	42,627,382.64
70101	80101	210201	Тэтгэврийн даатгал	32,671,400.00	29,241,367.28
70101	80101	210202	Тэтгэмжийн даатгал	3,843,700.00	3,621,895.19
70101	80101	210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,900.00	2,235,565.33
70101	80101	210204	Ажилгүйдлийн даатгал	768,700.00	768,700.00
70101	80101	210205	Эрүүл мэндийн даатгал	7,687,500.00	6,759,854.84
70101	80101	2104	Хангамж, бараа материалын зардал	20,215,400.00	18,733,812.90
70101	80101	210401	Бичиг хэрэг	13,616,800.00	13,601,800.00
70101	80101	210402	Тээвэр, шатахуун	1,593,600.00	1,593,600.00
70101	80101	210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,256,600.00	790,012.90
70101	80101	210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,748,400.00	2,748,400.00

70101	80101	2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,015,300.00	65,015,300.00
70101	80101	210601	Багаж, техник, хэрэгсэл	39,485,300.00	39,485,300.00
70101	80101	210602	Тавилга	21,530,000.00	21,530,000.00
70101	80101	210604	Урсгал засвар	4,000,000.00	4,000,000.00
70101	80101	2107	Томилолт, зочны зардал	25,316,000.00	25,220,100.00
70101	80101	210702	Дотоод албан томилолт	25,316,000.00	25,220,100.00
70101	80101	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,267,500.00	26,074,852.00
70101	80101	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,380,000.00	20,380,000.00
70101	80101	210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
70101	80101	210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	212,852.00
70101	80101	210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,500.00	22,000.00
70101	80101	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,060,000.00	5,060,000.00
70101	80101	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,712,500.00	131,711,587.00
70101	80101	2132	Бусад урсгал шилжүүлэг	131,712,500.00	131,711,587.00
70101	80101	213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,805,900.00	52,805,900.00
70101	80101	213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,233,600.00	36,233,600.00
70101	80101	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,673,000.00	42,672,087.00
70101	80101	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	55,047,586.46
70101	80101	2200	Дотоод эх үүсвэрээр	-	55,047,586.46
	80101	261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		55,046,673.46
70101	80101		ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	700,942,200.00	631,894,613.54
70101	80101	1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	686,942,200.00	631,894,613.54
70101	80101	132001	Орон нутгийн төсвөөс	686,942,200.00	631,894,613.54
70101	80101	120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,000,000.00	-
70101	80101	1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,000,000.00	
		62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	9.00
		620001	Удирдах ажилтан	1.00	1.00
		620002	Гүйцэтгэх ажилтан	6.00	5.00
		620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хариуцлагатай, ил тод, нээлттэй зохион байгуулан тэгш, шударга өрсөлдөх таатай орчинг бүрдүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой Аймгийн Засаг даргын дэргэдэх байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль,
- Зөрчлийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль,
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 8, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 3, Хөдөлмөрийн тухай хуульд 5, Төрийн албаны тухай хуульд 5 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Засгийн газрын 128 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг"-г шинэчлэн тогтоож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/255 тоот захирамжаар батлагдсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг байгууллагын санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газар 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмыг шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 237,874.4 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0	0
Авлага		0	0
Бараа материал		6,320.4	6,320.4
Үндсэн хөрөнгө		231,554.0	231,554.0
Нийт хөрөнгө		237,874.4	237,874.4
Өр төлбөр		0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		237,874.4	237,874.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		237,874.4	237,874.4

Дээрх хүснэгтээс харахад байгууллага шинээр байгуулагдсан 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн Засаг даргын А/89 дүгээр захирамжаар Орон нутгийн Өмчийн газраас 1,448.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 22,393.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 17,538.7 мянга төгрөгийн бараа материал зарцуулж 6,320.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант онд дээрхи захирамжаар Орон нутгийн Өмчийн газраас 246,506.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, төсвийн хөрөнгөөр 62,665.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 32,216.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 1,359.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2024 онд байгуулагдсан тул 2024 оны төсвийн төсөл хийгдээгүй байна.

Тайлант онд 686,942.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, төсвийн хуваарьт 2 удаагийн өөрчлөлт орсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр Худалдан авах ажиллагаа 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 686,942.2 мянган төгрөгийг Орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр 686,942.2 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 55,046.7 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 686,942.2 мянган төгрөг буюу 91.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг цалин, хөлс нэмэгдэл урамшуулал 27,137.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх дүн 5,418.9 мянган төгрөг, Хангамжийн зардал 1,481.6 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 192.0, нийт санхүүжилтэд орсон үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлогоос зарцуулаагүй 20,046.1 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Хөтөлбөр					
1	Худалдан авах ажиллагааны	686,942.2	631,895.5	55,046.7	91.9%
Арга хэмжээ					
1	Урсгал зардал	551,729.7	496,684.0	55,045.7	91.9%
2	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500.0	3,500.0	0.00	100.0%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	131,712.5	131,711.6	0.9	100.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого орж ирээгүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд тус байгууллага Улсын болон орон нутгийн төсвөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 62,665.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 22,393.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна..

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, Тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 686,942.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,869.4 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тухайн хуулийн 15 дугаар зүйлийн 1.2-д зааснаар чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоогоогүй арга хэмжээ авч ажилласан сайн тал байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн завсрын Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг талбарт 6,800.0 мянган төгрөгийг орхигдуулж мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх"; 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн байршуулсан байх гэсэн зөвлөмж хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцлийн асуудлыг үнэлэх асуудал үүсээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 1-3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, аудитын явцад үйл ажиллагаатай танилцаж, харилцах, цалин хөлсний баримтад анхан шатны баримтаас хөөн шалгасан. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилд асуудлын бүртгэл хөтөлж, дарга, нягтлан бодогч нарт танилцуулж, баталгаажуулсан.

Асуудлын бүртгэлээр 2 зөвлөмжийн биелэлтийг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж, 1 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор хангуулахаар тогтоосон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тайлант оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс шинээр байгуулагдсан тул өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн байхгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар даргын тушаал шийдвэр, үндсэн хөрөнгийн дансыг дахин авч үзэж болох юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Бараа материалын анхан шатны баримт шаардах хуудас бичсэн болон хүлээн авсан ажилтны гарын үсгийн бүрдэл хангалтгүй байгаа нь УСНББОУС 1, 12 болон аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй тул байгууллагын бараа материалын тодруулга тайланд залруулав,

Аудитаар нийт 3,978.4 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 3,978.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитаар залруулаагүй 3 зөрчилтэй асуудал нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн албан хаагчдыг нийт 3,978.4 мянган төгрөгөөр шагнасанд албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Захиргаа, үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо албан хаагчдын ур чадварыг шалгуур үзүүлэлтээр үнэлэлгүй нийт 6,388.1 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Ур чадварын нэмэгдэл олгохдоо үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг шалгуур үзүүлэлтээр үнэлж олгох.

2.Хуулийн хээргжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг талбарт 6,800.0 мянган төгрөгийг орхигдуулж мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэлээллийг иж бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын анхан шатны баримт шаардах хуудас бичсэн болон хүлээн авсан ажилтны гарын үсгийн бүрдэл хангалтгүй.	1	0	1	0			1	0				
Дүн	1	0	1	0			1	0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А767 дугаар захирамжийг үндэслэн албан хаагчдыг нийт 3,978.4 мянган төгрөгөөр шагнасан байна.	1	3,978.4			1	3,978.4						
Захиргаа, үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгохдоо албан хаагчдын ур чадварыг шалгуур үзүүлэлтээр үнэлэлгүй нийт 6,388.1 мянган	1	0						1	0			



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.17 № 02
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХУДАЛДАН
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОЮУНБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/845 дугаар захирамжийн дагуу Худалдан авах ажиллагааны газрыг байгуулж, 10 хүний бүрэлдэхүүнтэй худалдан авах ажиллагааг хуулийн дагуу хариуцлагатай, ил тод, нээлттэй зохион байгуулан тэгш, шударга өрсөлдөх таатай орчинг бүрдүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/89 дүгээр захирамжаар Орон нутгийн Өмчийн газраас 247,716.4 мянган төгрөгийн 207 ширхэг үндсэн хөрөнгө, 1,448.0 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэх авч, төсвийн хөрөнгөөр 62,665.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 22,393.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 100 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2025 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 015/A1470343
ОРА-2025/088/НА - СТА-7443

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Худалдан авах ажиллагааны газрын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн албан хаагчдыг нийт 3,978,450 (гурван сая есөн зуун далан найман мянга дөрвөн зуун тавин) төгрөгөөр шагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.3-д "Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3.3-д "Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно. Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл

байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан албан хаагчдыг шагнасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Худалдан ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Оюунбаяр), нягтлан бодогч (Г.Бүдхүү) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР:  П.ПҮРЭВЛХАГВА

АУДИТЫН

МЕНЕЖЕР:  Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:  Ж.НАРАНЧИМЭГ